



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№44 /488/

2023.03.14

Тусгай дугаар



"МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР", ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 102 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ!

МЭНДЧИЛТЭЭ



Эх орны сүр хүч, сүлд хийморийн нлэрхийлэл болсон Зэвсэгт хүчний нийт албан хаагчид, бэлтгэл болон бэлөнд байгаа ахмад дайнд Ша бүхэндээ "Монгол цэргийн өдөр", Орны цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

"Монгол цэргийн өдөр" бол эх орноо батлан хамгаалах нэр хүндтэй, харьцуулагатай цэргийн биелцүүлж яваа Зэвсэгт хүчний нийт албан хаагчид, төдийгүй улс орны тусгаар тогтнолын үнэ үнэ, Монгол цэргийн баатарлаг түүх, дайны замналыг иргэд, түмэн олондоо сурталчлан таниулах, эх орныхоо төлөө амьгасаа зориулсан эрхтэй үрэг эрч, эх оронд охид ховгүүдийнхээ алдар гавьяаг дурсах, алдаршуулан мөнхжүүлэх баатарлаг хүндэтгэлийн өдөр байдаг.

Эх орноо батлан хамгаалах үүрэгээ нэр төртэй гүйцэтгэсэн бага дарга нарын холбооны хорин мянга гаруй гишүүд та бүхэндээ амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье.

БАГА ДАРГА НАРЫН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН АХЛАХ ТҮРҮҮЧ Р.ДАГВА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар "Цэргийн андууд 2023" дурсамж уулзалтыг Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тохиолдуулан 5 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байна.

Улсын санаачилгаар "Цэргийн андууд 2023" дурсамж уулзалтыг Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тохиолдуулан 5 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байна.

Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба тэргүүтэй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагууд, алба хааж байсан жагсаалын дарга, бага дарга нар оролцож байна. "Цэргийн андууд" дурсамж



Энэхүү дурсамж уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, ЗГХЭГ-ын дэд дарга Б.Энх-Амгалан, Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх дэслэгч генерал Ц.Тогоо болон Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал

уулзалтыг нээж Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хэлсэн үгэндээ хүрэлцэн ирсэн үе үеийн бага дарга нарынхаа амрыг эрэн мэндчилээд Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийн баярын мэндийг дэвшүүллээ.

дээжсээ өргөн барьж байна. Түүнчлэн мөр зэрэгцэн алба хааж явсан цэргийн андуудаа хүндэтгэж МУАЖ Д.Жаргалсайхан, бэлтгэл хошууч Ж.Болдбаатар, Б.Базардорж болон "Хурд", "Хар сарнай", "Fige" хамтлагууд ая дуугаа өргөхөөр иржээ.

МАНАЙ ХАМТ ОЛОН



2019 онд Бага тушаалын том дарга эрхмүүдийн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн холбоо бөгөөд өдгөө 21 аймаг, 9 дүүрэгт, 20 гаруй мянган гишүүнтэйгээр эх оронч үндэсний үзэл бахархлыг хөгжүүлэн ард түмнээ соён гэгээрүүлж Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлаа үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх үйлсэд төр, иргэний нийгмийн байгууллагатай хамтран зүтгэж байна.





БАГА ДАРГА НАР ЯРЬЖ БАЙНА

ЦЭРГИЙН АЛБА ААВЫН ХӨВГҮҮДИЙГ БАГАГҮЙ СОРЬЖ, ХАТУУЖУУЛДАГ



Бага дарга ахлах түрүүч Д.ХОРЛОО:

-1979 онд Өмнөговь аймгийн дунд сургуулийг дүүргээд 1985 онд Ардын Армийн буюу Зүүнбаяны гэх тодотголтой 169 дүгээр

хороонд цэрэгт татагдсан. 1986 онд жагсаалын дарга болсны дараагаар Барилгын цэргийн 012 дугаар анги руу шилжиж салааны орлогч, эвлэлийн хороон даргаар алба хааж байгаад ахлах түрүүч цолтой 1988 онд халагдаж байлаа.

18 нас хүрээд даруй цэрэгт яваагүй, ажил хөдөлмөр эрхлэх зэргээр хувийн амьдрал хөөж байгаад арай хожуу цэрэгт очсон болохоор хөгшин цэрэг байсан. Тухайн үед бага дарга нарыг сонгохдоо зан ааш, хандлагыг их чухалчилж үздэг байсан юм болов уу даа. Учир нь хэтэрхий сагсуу нөхөрт тэр олон эрсийг захирах эрх мэдлийг өгчихвөл элдэв асуудал гарах магадлал өндөр. Миний хувьд он жавуудаасаа насны хувьд ах, зан ааш хандлага, арай төлөвшчихсөн багадаа басхүү барилдаж, ноцолдож явсан учир бие бялдрын хөгжил давгүй байсан болохоор дарга нарын нүдэнд өртсөн байх. Алба хаах хугацаандаа дарга нарын өгсөн үүргийг аль болох түргэн шуурхай биелүүлж, бусад нөхдөө манлайлагч байхыг хичээдэг байсан. Тухайлбал, өглөө нар мандахад манай рот хамгийн түрүүнд бэлэн жагсаад өглөөний гүйлтдээ гардаг байлаа. Энэ мэтчилэн бусад зүйлс дээр ч ротоо манлайлагч, үлгэр жишээ байхад анхаардаг байсан.

Зүүнбаянд 3 жилийн алба хаана гэдэг аавын хөвүүдийг багагүй сорьдог, хатуужуулдаг байсан. Жишээлбэл Дорнод аймгаас татагдаж ирсэн байлдагч говийн аагим халуун наранд цаг зогсолгүй унаад ойчдог байсан бол жилийн дараа гэхэд түүн шиг хурдан гүйдэг, түүн шиг хаттай болж бие бялдар нь чийрэгжсэн хүн байгаагүй юм даа. Энэ мэт яривал маш их зүйл байгаа учраас яриагаа энэ хүргээд өндөрлөө.

Өнөөдөр армид бага даргаар алба хаасан сайн эрчүүд энэ танхимд хуран чуулсан байна. Ингээд эдгээр нөхдөөдөө болон үе үеийн дарга нар, ах нартаа Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн мэндийг өргөн дэвшүүлье.

НАЙЗЫНХ НЬ ОРОНД НАЙЗ, ААВЫНХ НЬ ОРОНД ААВ БОЛЖ ЧАДДАГ ЭРЧҮҮД ЭНЭ ЦОЛЫГ ХҮРТДЭГ

Бага дарга түрүүч Н.ГАНЧУЛУУН:

-1979 онд Хэнтий аймгаас цэрэгт мордож Хилийн цэргийн 0198 дугаар ангид гурван жил алба хаагаад түрүүч цолтой халагдсан.

Алба хаах хугацаандаа тухайн үед 2 удаагийн Улсын их баяр наадмын парадад онжавуудаа ахлан оролцож явлаа. Тухайн үеийн Ардын Армид бага даргаар алба хаана гэдэг асар их үүрэг хариуцлагатай бахархам сайхан нэр хүндийн эзэн болдог байж.

Тухайлбал, цэргийн хэргийн мэдлэг, бие бялдрын бэлтгэлжилт, албандаа хандах хандлагаараа бусад нөхдөө манлайлж найзынх нь оронд найз, аавынх оронд аав болж чаддаг эрчүүд эл цолыг хүртдэг байсан гэж ойлгодог. Хүн ер нь олны дунд орсон цагаасаа би хэн бэ гэдэг асуултын хариултыг тасралтгүй эрж хайж олон дахин эргэцүүлж, ухааж ойлгодог. Энэ нь эргээд ирээдүйд таарах өөр өөр зан авиртай хүмүүстэй харилцах, гар нийлж ажиллах цаашлаад нөхөрлөхөд маш том дэмжлэг болдог.

Товчхондоо энэ мэтчилэн цэргийн албанаас сурсан зүйлс минь өдгөө хүртэл амьдралд минь ихээхэн дэм болж байна. Тиймээс залуу дүү нар минь заавал цэрэгт явж аагим халуунд гар түлчих вий гэмээр халуун хар цайг ойчихдоо түүнээс амьдралын амтыг мэдрээсэй гэж хүсдэг. Хэтэрхий их жаргал дунд хэсэгхэн зовлон бас амттай гэсэн үг бий. Арми гэдэг амархан даваа байсан бол дан ганц эр хүн хаах ёстой гэсэн утга юу байх билээ. Товчхондоо миний хувьд Монгол Улсын Ардын Арми гэдэг сүр жавхаа, хүч чадал, техник хэрэгслээрээ дэлхийд дээгүүр хэмжээнд яригдаж байсан үед 3 жилийн алба хаасандаа юу юунаас илүү бахархаж явдаг даа.



ЗАЛУУ НАС-ЭР ЦЭРЭГ



Ж.Жавзандулам гэр бүлийн хамт

Бага дарга ахлах түрүүч Ж.ЖАВЗАНДУЛАМ:

-Анх 1997 онд Цагдаагийн дээд сургуульд элсэн орсны дараагаар манай сургууль нэрээ өөрчилж Цагдаагийн академи болж миний бие эл нэртэй болсноос хойших анхны жагсаалын дарга болж явсан түүхтэй. Энэ цаг мөчөөс хойш олон нийтэд үйлчлэх, хүн

ардынхаа аюулгүй байдлыг сахин хамгаалах тангараг өргөж цагдаагийн ахмад цолонд хүртлээ үнэнч ажиллаж байна. Академийн сонсогч байх үед жагсаалч байдал, албандаа хандах хандлагыг минь тухайн үед штабын орлогч дарга байсан дэд хурандаа Ц.Чулуунбаатар дарга анзаарч "цагдаа болох" эхлэлийг тавьж өгсөн. Энэ мэт

яривал дууссашгүй их түүх бий. Товчхондоо гэж хэлэхэд академид мөр зэрэгцэн зүтгэж явсан онжавууд минь өдгөө цагдаагийн байгууллагыг ахлах эрхэм үйлсийг түүцээлж явна. Тухайлбал бид бүгдийн дундаас 33 хурандаа цолтон төрөн гарсан байна. Эдгээр мундаг, эрэмгий залуусыг удирдаж, манлайлж явсандаа бахархаж, омогшиж явдаг. Эр цэргийн алба гэдэг ямар ч их дээд сургуульд заадаггүй зүйлсийг заадаг эрхэм алба юм. Залуу хүн онож, алдахдаа амархан тийм насандаа цэрэгт явах нь хамгийн чухал. Олон аавын хөвгүүдтэй хамт нэгэн тогооноос хоол идэж, нэгэн жагсаалд жигдэрч, хөл нийлүүлж алхахаас эхлээд олонтойгоо явах арга ухаанд суралцдаг, хүний арга эвийг олох, үг даах зэргээр хатуужиж төлөвшдөг. Хамгийн наад зах нь цэргийн албанаас эдгээр зүйлсийг бүрэн суралцаж, дадсан байдаг. Хүний амьдрал баялаг, хорвоо дэлхий уужим учир амьдралд юу ч тохиолдож болно. Харин энэ үед цэргийн албанаас сурч мэдсэн зүйлс тулах цэг түших багана болдог онцлогтой гэж болдог.

ЖИН ТЭЭЖ АТ БОЛДОГ ЦЭРЭГТ ЯВЖ ЭР БОЛДОГ



Р.Энхбаяр гэр бүлийн хамт

Бага дарга түрүүч Р.ЭНХБАЯР:

-1989-1991 онд Ардын Армийн 167 дугаар анги буюу Танкын батальоны мотобуудлагын ротод эмнэлгийн зааварлагч бага даргаар алба хаасан. Манай хороо тухайн үед хурандаа н.Санжаа захиралтай, дэд хурандаа н.Баярхүү штабын даргаар ахлуулсан 1000 гаруй

цэрэгтэй 7-8 батальон нийлсэн том хэмжээний хороо байлаа. Миний бие эл хороонд алба хааснаараа бахархаж, дурсаж явдаг. Учир нь тухайн үеийн цэргийн алба гэдэг хүнийг жинхэнэ утгаар нь хүмүүжүүлдэг, төлөвшүүлдэг, амьдралд бэлтгэдэг байлаа. Бага дарга нарын хувьд тэрхүү олон он жавууд дотроосоо биеэ авч яваа

байдал, сэтгэл зүй болон бие бялдрын бэлтгэлжилтээрээ онцгой байсан залуус сонгогдож бусад нөхдөө удирдах, манлайлах, чиглүүлэх, зааварлах эрхэм үүргийг хүлээдэг байсан. Намайг алба хаах хугацаанд олон ч мундаг бага дарга нар байсны зэрэгцээ цолгүй хэдий ч бусад нөхдөө манлайлагч олон цэргүүд байсан. Тухайлбал Ж.Болдбаатар, А.Насанбаатар, Б.Болдбаатар, С.Өлзийсайхан зэрэг албаа үлгэр жишээ хаасан залуусыг энд онцлох нь зүйтэй.

Намайг бага залуу явахад цэргийн албыг 3 жил заавал биеэр хаадаг тийм жишиг нийгэмд, хүмүүсийн тархинд бат бөх суусан, түүнийг хааж байж л эр хүн болдог гэдэг ойлголтой байлаа. Гэтэл одоо үед ганцхан жил хүрэхтэй үгүйтэй хугацаанд алба хааж байна. Тэгсэн атлаа цэргийн албанаас янз бүрийн аргаар хоцорч үлдэх, ухрах, няцах тохиолдлууд их гарах болж. Залуус ирээдүй хойч үедээ захиж хэлэхэд жин тээж ат болдог, цэрэгт явж эр болдог юм шүү гэдгийг хэлмээр байна.

Ингээд олон зүйлийг эс нурушин энэхүү хүндэтгэлийн өргөөнд хуран цугласан эрхэм бага дарга нар, онжавууд болон үе үеийн удирдлагууд, хүрэлцэн ирсэн хүндэт зочдодоо Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.